

**“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 02/23

Улаанбаатар хот

**Ногдол ашгийн бодлогын баримт бичигт  
өөрчлөлт оруулах батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, 80 дугаар зүйлийн 80.4 дахь заалт, СЗХ-ны 2022 оны 145 тоот “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн батлах тухай тогтоол, “Булигаар” ХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. “Булигаар” Хувьцаат компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх “Ногдол ашгийн бодлого”-ыг Нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.
- Хоёр. Энэхүү бодлогын баримт бичиг батлагдсантай холбоотойгоор 2022 оны 21/22 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ногдол ашгийн бодлого”-ын баримт бичгийг хүчингүй болсонд тооцсугай.
- Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд, хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.ЭНХМЭНД



Баримт бичгийн нэр:

**БУЛИГААР ХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ**

<b>Баримт бичгийн дугаар:</b>	Б23-ТУЗ-02-02
<b>Баталсан огноо:</b>	2023-02-15
<b>Өөрчлөлтийн утга:</b>	Шинээр баталсан
<b>Өөрчлөлт оруулсан ажилтан:</b>	
<b>Мөрдөж эхлэх огноо:</b>	2023-02-15
<b>Боловсруулсан:</b>	ТУЗ-ийн хараат бус гишүүд
<b>Хянасан:</b>	ТУЗ-ийн дарга
<b>Журамд хяналт хийх хугацаа:</b>	Шаардлагатай тохиолдолд
<b>Журмын эх хувь хадгалах:</b>	1 эх хувь ТУЗ-ийн нарийн бичиг
<b>Хуудасны тоо:</b>	2 хуудас
<b>Танилцах:</b>	ТУЗ-ийн нийт гишүүд, Гүйцэтгэх удирдлага


Улаанбаатар хот

2023 он

## АГУУЛГА

<b>НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО .....</b>	<b>1</b>
Нэг. Нийтлэг үндэслэл .....	1
Хоёр. Ногдол ашгийн бодлого.....	1
Гурав. Ногдол ашгийн хэмжээг тодорхойлох .....	2
Дөрөв. Ногдол ашиг хуваарилах, мэдээлэх, тайлагнах.....	2

“Булигаар” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн  
02/23 тоот тогтоолын Нэгдүгээр хавсралт



## БУЛИГААР ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү ногдол ашгийн бодлого (цаашид “бодлого” гэх)-оор Булигаар ХК (цаашид “Компани” гэх)-ийн ногдол ашгийн бодлогын баримт бичиг бөгөөд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэр гаргах, хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, энэ талаарх шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашгийг төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Журам нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль, компанийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлөөс энэхүү журмыг баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

### Хоёр. Ногдол ашгийн бодлого

- 2.1. Компани нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг бизнесийн үйл ажиллагаанд зүй зохистой, үр ашигтай захиран зарцуулж, тогтвортой ногдол ашгийн бодлого баримтална. Компанийн тухайн жилийн үндсэн үйл ажиллагааны цэвэр ашгийн 5-аас доошгүй хувийг ногдол ашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.
- 2.2. Компани нь дараах нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна. Үүнд:
  - 2.2.1. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
  - 2.2.2. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;
  - 2.2.3. Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүгдийг нь эргүүлэн авсан байх;
- 2.3. Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргана.
- 2.4. Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн нөхцөлд тухайн шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж тайлагнана.
- 2.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт хувьцааны төрөл тус бүрээр нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр, ногдол ашиг төлөх өдөр, ногдол ашгийг олгох арга зам, хэлбэр (эрх бүхий зуучлагчаар дамжуулах, эд хөрөнгө, бэлэн мөнгө, бусад үнэт цаасаар төлөх гэх мэт) зэрэг холбогдох бусад асуудлыг тусгана.

- 2.6. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгаа төлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчдэдээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийг бичгээр мэдэгдэх үүргийг гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.

### **Гурав. Ногдол ашгийн хэмжээг тодорхойлох**

- 3.1. ТУЗ нь ногдол ашгийг тодорхойлсон тооцооллыг тухайн жилд хэлэлцэж гаргана.

### **Дөрөв. Ногдол ашиг хуваарилах, мэдээлэх, тайлагнах**

- 4.1. ТУЗ нь ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу бүртгэлийн өдрийг тогтоох бөгөөд тухайн өдрөөр тасалбар болгосон нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрх үүснэ.
- 4.2. Компани ногдол ашиг хуваарилахад Компанийн тухай хуулийн 46-47 дугаар зүйлд заасан нөхцөл, журмыг хангасан байна.
- 4.3. Ногдол ашиг олгох өдөр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсанаас хойш 60-аас илүүгүй хоног байхаар тооцож ногдол ашиг тараах хугацааг тогтоовол зохимжтой.
- 4.4. Компани ногдол ашиг хуваарилахтай холбоотой мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд хүргэхээс гадна саадгүй танилцах боломжийг бүрдүүлнэ.
- 4.5. Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх хүртэлх хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд уг хувьцаанд ногдох ногдол ашгийг авах эрх нь хуучин хувьцаа эзэмшигчид үлдэнэ.
- 4.6. Хувьцаа эзэмшигчдэд төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг төлбөл зохих өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгаж, ногдол ашиг төлж эхэлсэн улирал болон жилийн эцэст олгоогүй байгаа ногдол ашгийг өглөгийн бүртгэлд бүртгэнэ.
- 4.7. Компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхээс гадна хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг тайлагнана.

-ооо-